

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024.12.16

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
Салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах		
1	Салбар хороо, хэсгийн хороод, багуудын гишүүдийн судалгааг шинэчлэх	Тайлант хугацаанд ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь БОЭТ-ийн дэргэдэх “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо”, Эрдэнэт сувиллын цогцолбор, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэргэдэх “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо”-г тус тус арга зүйгээр ханган ажиллалаа. Тус хороодын гишүүдийн судалгааг бүрэн шинэчилсэн. <i>Хэрэгжилт 100%</i>
2	Салбар хороо, хэсгийн хороод, багуудын гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн хорооны гишүүн Н.Алтанцоож багш нь ЭМГ, БОЭТ, Мөнхсүндрэл, Үйлсбадрах, Нийцэл, Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ёс зүйн хороод, багуудын нийт 26 гишүүнд чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Мөн ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг 1 удаа зохион байгуулсан бөгөөд Эрүүл мэндийн газраас 70.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. <i>Хэрэгжилт 100%</i>
3	Өргөдөл гомдлыг хүлээн авах бүртгэх, хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх арга хэмжээг тухай бүрт нь шуурхай зохион байгуулах	Тайлант хугацаанд ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 2 өргөдөл ирсэн бөгөөд өргөдлийн мөрөөр ажиллах удирдамж батлуулан 2 баг ажилласан. Ёс зүйн даргаар батлуулсан уг удирдамжийн дагуу 2 баг ажиллаж ээлжит бус 3 удаагийн хурлаар хэлэлцүүлэн 7 шийдвэр гарган хэрэгжүүлж ажилласан. Тус хурлаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд болон Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийн дэргэдэх ёс зүйн багт эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд ЭМС-ын 2019 оны А/406-р тушаал буюу эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм болон хүчирхийлэлд өртсөн, өртсөн байх магадлалтай үйлчлүүлэгчтэй хэрхэн харьцах, хувь хүний нууцыг чандлан хадгалах чиглэлээр сургалтад хамруулж, тайланг ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар хороонд албан тоотоор ирүүлэх үүрэг чиглэлийг өгч, тус сургалтыг 3-р улиралд зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. <i>Хэрэгжилт 100%</i>
4	Албан хаагч, үйлчлүүлэгч хоорондын ёс зүйн маргааны үед эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тайлант хугацаанд албан хаагч, үйлчлүүлэгч хоорондын ёс зүйн маргаан гарч эвлэрүүлэн зуучилсан тохиолдол бүртгэгдээгүй. ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 2 өргөдөл ирсний дагуу удирдамж батлуулан, хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. <i>Хэрэгжилт 100%</i>
5	Хэсгийн хороо, багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Тайлант хугацаанд 8 өрхийн эрүүл мэндийн төвийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн баг”-ийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийсэн бөгөөд тус хяналтаар Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Дүрэм батлах тухай” А/256 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” А/406 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалын хэрэгжилт хангалтгүй байна. Нийтлэг зөрчлүүд:

		- Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ёс зүйн багийн үйл ажиллагаа Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 дугаар тушаалын дагуу явагддаггүй. - Хурлын төлөвлөгөө, тэмдэглэл байхгүй байгаа нь тус багууд нь огт хуралддаггүй, мөн гишүүдийн оролцоогүйгээр зөвхөн дарга нь шийдвэр гаргадаг. - Ёс зүйн багийн үйл ажиллагаа нь ил тод биш, эрүүл мэндийн ажилчдын нэр хүндийг өсгөх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг таниулах, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хангалтгүй зохион байгуулж байна. <i>Сайн туршлага:</i> - “Анхны –Оч” өрхийн эрүүл мэндийн төвийн ёс зүйн багаас гаргасан хуваарийн дагуу тус төвийн ажилтнууд сар бүр ёс зүй, харилцаа хандлагын сургалтыг зохион байгуулж байна. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь сэтгэл зүйн өрөөг тохижуулан, сэтгэл зүйчтэй хамтран ажиллах гэрээ байгуулан иргэдэд болон ажилчдад ганцаарчилсан зөвлөгөөг өгч ажиллаж байна. - “Үйлсбадрах” өрхийн эрүүл мэндийн төв нь “Ёс зүйтэй ажилтан” 1 сарын аян зарлаж шилдэг ажилтан шалгаруулсан зэрэг сайн туршлагууд байна. Тус сайн туршлагуудыг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сурталчилж ажилласан. <i>Хэрэгжилт 100%</i>
6	Жилийн турш тогтмол сайн ажилласан ёс зүйн хэсгийн хороод, багийг удирдамжийн дагуу шалгаруулж, шагнаж урамшуулах	Жилийн турш тогтмол сайн ажилласан ёс зүйн хэсгийн хороод, багийг шалгаруулах удирдамжийг батлуулан ажилласан бөгөөд 9 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн баг, 2 Эмнэлгийн мэргэжилтний хэсгийн хорооны материал ирснээс Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. <i>Хэрэгжилт 100%</i>
7	Холбогдох мэдээ, тайланг ЭМГ-ын удирдлагууд, ЭМЯ-ны хяналтын хороонд хүргүүлж хамтран ажиллах	ЭМС-ын 2017 оны А/256 дугаар, 2019 оны А/19 дүгээр тус тус тушаалын дагуу хагас болон бүтэн жилээр тайланг нэгтгэн ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хугацаанд нь хүргүүлсэн. <i>Хэрэгжилт 100%</i>
8	Салбар хорооны жил бүрийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг холбогдох зааврын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж архивт шилжүүлэх	2025 оны 1-р улиралд архивын материалыг ЭМГ-ын архив бичиг хэргийн ажилтанд хүлээлгэж өгөхөөр архивын нэг хадгаламжийн нэгжийг бүрдүүлсэн байна. <i>Хэрэгжилт 100%</i>
Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр мэдлэг, чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлэх		
9	ЭМГ-ын дэргэдэх Ёс зүйн салбар хорооны цахим хуудсыг тогтмол ажиллуулан, мэдээллээр хангах, мэдээлэл бүрийг ЭМГ-ын цахим хуудас болон сайтад тогтмол нийтлэх	ЭМГ-ын ёс зүйн салбар хороо,ЭМБ-ын ёс зүйн салбар хороо,хэсгийн хороо, багуудын фейсбүүк групп болон Орхон аймгийн ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар хорооны пэйж хуудсанд сургалт мэдээллийн чиглэлээр 13, ЭМГ-ын цахим хуудасны ил тод цэст Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээрх хууль эрх зүй, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан <i>Хэрэгжилт 100%</i>
10	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлагыг тодорхойлох	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулатори болон хэвтэн эмчлүүлэгсдээс эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлагыг тодорхойлох судалгааг авахад:

	судалгааг иргэдээс авах, танилцуулах	- Амбулаторийн тусламж үйлчилгээ авсан 546 үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 79% байна. Үүнээс эмч, сувилагчийн харьцаа хандлага, үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй харьцах байдал 70,9% буюу хангалттай үнэлэгдэж өмнөх онтой харьцуулахад 6,9%-аар өссөн. - Хэвтэн эмчлүүлсэн 1353 үйлчлүүлэгчээс судалгаа авахад эмчийн харилцаа хандлага өмнөх оноос 10.7%-аар, сувилагчийн харилцаа хандлага 4.82%-аар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 87%-тай байна. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагаар үйлчлүүлэгсдийн сэтгэл ханамжийн судалгааг SERVQUAL аргаар 5 бүлэг 22 асуумжаар. 392 иргэнээс авч үнэлэхэд 3.6 (1-5 оноо) буюу 72%-тай үнэлэгдсэн бөгөөд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Эрүүл мэндийн газраас үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. <i>Хэрэгжилт 100%</i>
11	Ёс зүйн мэдлэг сорих сорил авах, дүгнэх	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 97 эмч, эмнэлгийн мэргэжилтнээс 20 /мэдлэг 20/ асуулт бүхий сорил авч, мэдлэг хандлагыг дүгнэсэн. Судалгаанд оролцогчдын зөв хариултын хувиар мэдлэгийг үнэлсэн. Хэрэв тухайн асуултад оролцогчдын 0-39% хариулбал мэдлэг маш муу, 40-59% бол хангалттай, 60-69% бол маш сайн гэж тооцсон. Сорил хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний мэдлэгийн түвшин 45% буюу хангалттай түвшинд байна. Сорилын төгсгөлд санал авахад сорилд оролцсон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн багц цагийн сургалтын үнэлгээ “Хангалттай” үнэлэгдсэн боловч ёс зүйн сургалтын сэдэв өөрчлөгддөггүй, нэг зааснаа давтдаг, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй гэхээс гадна нийгмийн ёс зүйг сайжруулах талаар санал бичсэн байна. Үүнээс үзэхэд цаашид сургалтыг явуулахдаа жил ёс зүйн мэдлэгийг үнэлэхэд сорил авах, эмч, эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж, зохион байгуулах хэлбэр, сэдвийг шинэчлэх, хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна. <i>Хэрэгжилт 100%</i>
12	Ёс зүйн чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулан соён гэгээрүүлэх чиглэлээр санхүүжилтийн дэмжлэг авах	Жилийн турш тогтмол сайн ажилласан ёс зүйн хэсгийн хороод, багийг болон Ёс зүйтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шалгаруулах удирдамжийг боловсруулан Эрүүл мэндийн газраас шагнал урамшуулалд 230.0 төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан. <i>Хэрэгжилт 70%</i>
13	Эмч, эмнэлгийн мэргэжилтний хууль эрх зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Ёс зүйн салбар хорооноос ЭМГ-ын албан хаагч, БОЭТ-ийн Амбулаторийн тасаг, Анхны-Оч, Мөнхсүндрэл, Үйлсбадрах, Нийцэл, Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 197 эрүүл мэндийн ажилтыг хамруулан соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан. <i>Хэрэгжилт 70%</i>
14	ЭМС-ын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт зохион байгуулах тухай” А/19-р тушаалын дагуу сар бүр удирдамж гарган сургалтыг	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр нийт 49 удаагийн соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд 2033 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. <i>Хэрэгжилт 100%</i>

	зохион байгуулах, тайланг ЭМГ-т ирүүлэх	
15	Тохиолдолд суурилсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагатай холбоотой тохиолдолд суурилсан сургалтыг 1 удаа зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл 45 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. <i>Хэрэгжилт 100%</i>
16	Ёс зүйтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шалгаруулж урамшуулах	Ёс зүйтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг шалгаруулах удирдамжийг батлуулан ажилласан бөгөөд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн баг, хэсгийн хороодоос 6 эмч, эмнэлгийн мэргэжилтний материал ирснээс шалгуур хангасан 1 эмчийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. <i>Хэрэгжилт 100%</i>
		Хэрэгжилт 96,3%

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЁС ЗҮЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С. МӨНХЗУЛ